



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/72

Сайнцагаан сум

Цагдаагийн дэд ахлагч О.Хүүхайчинд  
сахилгын шийтгэл оногдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.6, 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл оногдуулах /код 914/ журам, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цагдаагийн газрын даргын 2022 оны 10 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Отгонбаярын Хүүхайчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ цагдаагийн дэд ахлагч Д.Идэрболдыг дарамталж биед нь гэмтэл учруулахгүйгээр халдаж, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.1, 2.4.2 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн тул албан тушаалын сарын үндсэн цалинг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.


2. Цагдаагийн дэд ахлагч О.Хүүхайчинд дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг, хариуцсан алба хаагчдад өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, зааварчилгаа өгч, үр дүнг тооцож ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Х.Ганболд/-д, хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Л.Мөнхчимэг/-д, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /цагдаагийн ахмад Ч.Сүрэнхорлоо/-д тус тус үүрэг болгосугай.

3. Цагдаагийн дэд ахлагч О.Хүүхайчингийн цалинг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс тушаалд заасан хувь хэмжээгээр хасаж, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй

4. Цагдаагийн дэд ахлагч О.Хүүхайчинг ёс зүйн сургалтад хамруулах, шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА  Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/73

Сайнцагаан сум

Цагдаагийн дэд ахлагч Н.Буджавт  
сахилгын шийтгэл оногдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.6, 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл оногдуулах /код 914/ журам, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2022 оны 10 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Наранцогийн Буджав согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ цагдаагийн дэд ахлагч Д.Идэрболдыг дарамталж биед нь гэмтэл учруулахгүйгээр халдаж, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.1, 2.4.2 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн тул албан тушаалын сарын үндсэн цалинг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн дэд ахлагч Н.Буджавт дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг, хариуцсан алба хаагчдад өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, зааварчилгаа өгч, үр дүнг тооцож ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Х.Ганболд/-д, хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Л.Мөнхчимэг/-д, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /цагдаагийн ахмад Ч.Сүрэнхорлоо/-д тус тус үүрэг болгосугай.

3. Цагдаагийн дэд ахлагч Н.Буджавын цалинг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс тушаалд заасан хувь хэмжээгээр хасаж, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй

4. Цагдаагийн дэд ахлагч Н.Буджавыг ёс зүйн сургалтад хамруулах, шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/74

Сайнцагаан сум

Улирлын ажлын үр дүнгээр алба хаагчдын цалинг нэмж, мөнгөн урамшуулал олгох, бууруулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын энэ оны 10 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр 2022 оны 02 дугаар улирлын ажлын тайлан, үр дүнг хэлэлцээд албан тушаалын сарын үндсэн цалинг 10-40 хувиар нэмж, мөнгөн урамшуулал олгох алба хаагчдын нэрсийн хавсралтаар баталсугай.

2. Алба хаагчдын цалинг тушаалд заасан хувь хэмжээгээр тооцож, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/35

Сайнцагаан сум

Цагдаагийн хошууч Б.Батгэрэлд сахилгын  
шийтгэл оногдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.6, 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Сахилгын шийтгэл оногдуулах /код 914/ журам, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2022 оны 10 дугаар зөвлөлийн хуралдаанаар Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд явуулсан дотоод хяналт шалгалтын дүнг хэлэлцээд тус тасгийн дарга, цагдаагийн хошууч Баярхүүгийн Батгэрэл хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, замын хөдөлгөөнд хяналт тавих, хөдөлгөөн зохицуулах, зохион байгуулах тасгийн үйл ажиллагааг удирдах албан тушаалын үндсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн байх тул албан тушаалын сарын үндсэн цалинг 3 /гурав/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн хошууч Б.Батгэрэлд албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо бүрэн хангаж ажиллахыг, хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Л.Мөнхчимэг/-д, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /цагдаагийн ахмад Ч.Сүрэнхорлоо/-д тус тус үүрэг болгосугай.


3. Цагдаагийн хошууч Б.Батгэрэлийн цалинг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс тушаалд заасан хувь хэмжээгээр хасаж, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй

4. Цагдаагийн хошууч Б.Батгэрэлийг ёс зүйн төлбөртэй сургалтад хамруулах, шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 5/96

Сайнцагаан сум

Цагдаагийн хошууч Т.Ганбаярт сахилгын  
шийтгэл оногдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.6, 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл оногдуулах /код 914/ журам, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2022 оны 10 дугаар зөвлөлийн хуралдаанаар Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд явуулсан дотоод хяналт шалгалтын дүнг хэлэлцээд тус тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Төмөрийн Ганбаяр харьяа нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний хяналт, зохицуулалт, хамгаалалтын үйл ажиллагааг хариуцаж, цагдаагийн төрөл мэргэжлийн бусад нэгж, алба хаагчтай харилцан ажиллах албан тушаалын үндсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн байх тул албан тушаалын сарын үндсэн цалинг 3 /гурав/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн хошууч Т.Ганбаярт албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо бүрэн хангаж ажиллахыг, хариуцсан алба хаагчдад өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, зааварчилгаа өгч, үр дүнг тооцож ажиллахыг Замын цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Батгэрэл/-д, хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Л.Мөнхчимэг/-д, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /цагдаагийн ахмад Ч.Сүрэнхорлоо/-д тус тус үүрэг болгосугай.

3. Цагдаагийн хошууч Т.Ганбаярын цалинг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс тушаалд заасан хувь хэмжээгээр хасаж, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

4. Цагдаагийн хошууч Т.Ганбаярыг ёс зүйн төлбөртэй сургалтад хамруулах, шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХБАТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/77

Сайнцагаан сум

Мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн  
алба хаагчдад нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, 57.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох /код 924/ журам”-ын 924.6 дахь хэсгийн 924.6.1-ийн “г”, “Алба хаагчийг мэргэжлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах /код-948/ журам”-ын 948.7.2, мөн даргын 2022 оны А/184 дүгээр тушаал, 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн нэр бүхий алба хаагчдын албан тушаалын сарын үндсэн цалинг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс нэмж олгосугай.

2. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох алба хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, нэмэгдэл ахих алба хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Алба хаагчдын цалинг хавсралтад дурдсан хувь хэмжээгээр тооцож, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6)78

Сайнцагаан сум

Албан тушаалын цалингийн зэрэглэл  
шинэчлэн батлах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаал батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цагдаагийн газрын мужаан Юндэнцэрэнгийн Цэндээхүүгийн цалинг ТҮ-3, үйлчлэгч Цэенпилийн Өлзийдэлгэрийн цалинг ТҮ-1 дүгээр зэрэглэлээр тус тус цалинжуулсугай.

2. Мужаан Ю.Цэндээхүү, үйлчлэгч Ц.Өлзийдэлгэр нарын цалин хөлсийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар Б/79

Сайнцагаан сум

Цагдаагийн дэслэгч С.Болдхэтийн  
цалинг тогтоох тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, 87 дугаар зүйлийн 87.9, Засгийн газрын 2014 оны 99, 2019 оны 472 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох /код 924/ журам”-ын 924.4.1, 924.4.2, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны Б/824 дүгээр тушаалаар тус газрын Баянжаргалан сум дахь хэсгийн төлөөлөгчөөр томилогдсон цагдаагийн дэслэгч Сайханбаярын Болдхэтийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ10 дугаар зэрэглэлийн 1 дүгээр шатлалаар, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 /хорин тав/, цолны нэмэгдлийг 30 /гуч/ хувиар тус тус тооцож олгосугай.

2. Цагдаагийн дэслэгч С.Болдхэтийн цалин хөлсийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Цагдаагийн дэслэгч С.Болдхэтийн ажлыг хүлээлцүүлж, тогтвортой ажиллах гэрээ байгуулан ажиллах, дадлагажуулагчаар Эрүүгийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Р.Саранболд/-ийг томилж, дасан зохицох арга хэмжээний хөтөлбөрт хамруулж, холбогдох хууль, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар зааварчилга өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үр дүнг тооцож ажиллахыг дадлагажуулагчид даалгасугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА  Б.МӨНХБАТ







ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар Б/80

Сайнцагаан сум

Цагдаагийн дэслэгч З.Ган-Эрдэнийн  
цалинг тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, 87 дугаар зүйлийн 87.9, Засгийн газрын 2014 оны 99, 2019 оны 472 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох /код 924/ журам”-ын 924.4.1, 924.4.2, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны Б/824 дүгээр тушаалаар тус газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн мөрдөгчөөр томилогдсон цагдаагийн дэслэгч Зоригоогийн Ган-Эрдэнийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ9 дүгээр зэрэглэлийн 1 дүгээр шатлалаар, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 /хорин тав/, цолны нэмэгдлийг 30 /гуч/ хувиар тус тус тооцож олгосугай.

2. Цагдаагийн дэслэгч З.Ган-Эрдэнийн цалин хөлсийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Цагдаагийн дэслэгч З.Ган-Эрдэнийн ажлыг хүлээлцүүлж, тогтвортой ажиллах гэрээ байгуулан ажиллах, дадлагажуулагчаар Эрүүгийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Р.Саранболд/-ийг томилж, дасан зохицох арга хэмжээний хөтөлбөрт хамруулж, холбогдох хууль, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар зааварчилга өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үр дүнг тооцож ажиллахыг дадлагажуулагчид даалгасугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 6/65


Сайнцагаан сум

「Алба хаагчдын төрийн тусгай алба хаасны болон цол, онцгой албаны нэмэгдэл, цалингийн шатлалыг шинэчлэн тогтоох тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 87 дугаар зүйлийн 87.9 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2019 оны 472 дугаар тогтоолын 3, 9 дугаар хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох” журам /код-924/ 924.3.6, 924.3.7, 924.4.1, 924.4.2, мөн даргын А/246 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код-136/ 136.5.2-ийн “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алба хаагч, ажилтны төрийн тусгай алба хаасны болон цол, онцгой албаны нэмэгдэл, үйлчилгээний алба хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цалингийн шатлалыг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс нөхөн олгосугай.
2. Албан тушаалын цалингийн шатлал зэрэглэл, нэмэгдэлд өөрчлөлт орсон алба хаагч, ажилтны цалинг хавсралтад зааснаар бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/70

Сайнцагаан сум

Нууцын бичээч цагдаагийн ахлах дэслэгч  
А.Ганзоригийн цалингийн нэмэгдлийг  
шинэчлэн тогтоох тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1 дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/106 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Тус газрын эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Алтанхуягийн Ганзоригийн нууцын бичээчийн нэмэгдлийг 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс албан тушаалын сарын үндсэн цалинг 15 /арван тав/ хувиар нэмж тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

2. Холбогдох хууль, тогтоомжид заасныг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг нууцын бичээчид үүрэг болгосугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 6/71

Сайнцагаан сум

Цалинтай чөлөө олгох тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид чөлөө олгох /код-934/ журам”-ын 934.2.1, 934.2.3, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус газрын жижүүрийн мөрдөгч, цагдаагийн ахлах ахлагч Мягмарсүрэнгийн Зандраа 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг дуустал ажлын 5 хоног.

Төлөвлөлт зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн хошууч Тунсагийн Розон 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал ажлын 2 хоногийн цалинтай чөлөөг тус тус олгосугай.

2. Алба хаагчдад чөлөөтэй байх хугацаандаа сахилга, ёс зүйг чанд сахиж, согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх, замын хөдөлгөөнд оролцохдоо аюулгүй байдлыг хангах, чөлөөний хугацааг хэтрүүлэхгүй байхыг тус тус үүрэг болгосугай.

3. Цалинтай чөлөө олгогдсон хугацааг зохих журмын дагуу тооцож, олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА  Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 6/63

Сайнцагаан сум

Цагдаагийн хошууч Б.Батгэрэлийн цалин,  
хөлсийг ажлын үр дүнгээр хасах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тээврийн цагдаагийн албанаас энэ оны 01 дүгээр сард баталсан "2022 онд төв, орон нутгийн хэмжээнд зам, тээврийн хяналт зохицуулалтын чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын календарьчилсан төлөвлөгөө"-ний дагуу 03 дугаар сард зохион байгуулах "Улсын дугаар" нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулаагүй, албан тушаалын зорилго зорилгоо хангалтгүй биелүүлсэн байх тул Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Баярхүүгийн Батгэрэлийн албан тушаалын сарын үндсэн цалинг ажлын үр дүнгээр 1/нэг сар/ 20/хорь/ хувь бууруулсугай.

2. Цагдаагийн хошууч Б.Батгэрэлд дээд шатны байгууллагаас ирүүлсэн үүрэг ажлын чиглэлийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах, дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллах, хариуцсан алба хаагчдад өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, зааварчилгаа өгч, үр дүнг тооцож ажиллахыг, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /цагдаагийн ахмад Ч.Сүрэнхорлоо/-д тус тус үүрэг болгосугай.

3. Цагдаагийн хошууч Б.Батгэрэлийн цалинг тушаалд заасан хувь хэмжээгээр хасаж, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

4. Цагдаагийн хошууч Б.Батгэрэлд Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА  Б.МӨНХБАТ

